

Сайжруулсан түлшний хэрэглээний туршилтын ажилд хамрагдсан өрхийн судалгааны үр дүнг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа

Нийслэлийн Агаарын чанарын алба нь Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4-т заасны дагуу сайжруулсан түлшний хэрэглээний судалгааг Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны сайжруулсан зуухтай 50 өрхөд “Шарын гол энерго”ХХК болон “Баялаг Эрдэнэ цом” ХХК-иудын нийт 16 тн сайжруулсан түлшийг өгч 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 23-ны өдрийг хүртэл 7 хоногийн турш хэрэглүүлэн үр дүнг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэлээ.

“Шарын гол энерго” ХХК-ын түлшийг хэрэглэсэн 28 өрх сайжруулсан түлшний талаар эерэг хандлагатай байсан бол “Баялаг Эрдэнэ цом” ХХК-ын түлшийг хэрэглэсэн 22 өрхийн хувьд сөрөг хандлагатай байлаа.

“Шарын гол энерго”ХХК-ийн сайжруулсан түлш

“Шарын гол Энгерго”ХХК-ийн түлшийг хэрэглэсэн 28 өрхийн санал асуулгын дүнгээс харахад уг сайжруулсан түлш нь хэрэглэхэд ямар нэгэн хүндрэлгүй, түүхий нүүрстэй харьцуулахад утаа, хөө тортог бага ялгаруулдаг, түлшний хэрэглээ бага хэмжээгээр буурах бөгөөд үлдэх үнсний хэмжээ багасна гэж үзсэн. Дутагдалтай тал нь асахдаа удаан, шатаж эхлэхдээ кабель, хаймар шатаж байгаа юм шиг үнэр гардаг.


Судалгаанд хамрагдсан өрхүүдийн 22 нь гэрийн зуухтай , 3 нь байшингийн ханан зуухтай ,3 нь усан халаалтын зуухтай байсан.



Судалгааг нийт 16 асуултын дагуу авсан бөгөөд хариултыг графикаар харуулав.


1. Сайжруулсан зууханд сайжруулсан түлш хэрэглэх нь хэр тохиромжтой байна вэ?

■ а. Тохиромжтой. ■ б. Тохиромжгүй.



2. Тохиромжгүй бол яагаад?


■ шаталт хурдан цог үлдэхгүй ■ тохиромжтой



Судалгаанд оролцсон ихэнх өрхүүд “Шарын гол энерго” ХХК-ийн сайжруулсан түлшийг хэрэглэхэд тохиромжтой байна гэж хариулсан байна.


3. Сайжруулсан түлшээр гал асаах нь түүхий нүүрснээс хялбар.

■ а. Санал нийлж байна. ■ б. Санал нийлэхгүй байна.



4. Сайжруулсан түлш нь түүхий нүүрстэй харьцуулахад утаа, хөө тортог бага ялгаруулдаг.


■ а. Санал нийлж байна. ■ б. Санал нийлэхгүй байна.



Сайжруулсан түлшээр гал асаах нь хялбар, түүхий нүүрстэй харьцуулахад утаа, хөө тортог бага ялгаруулж байна.


5.Сайжруулсан түлш хэрэглэснээр түлшний хэрэглээ багасна.

- а.Санал нийлж байна.
- б.Санал нийлэхгүй байна.
- в.Мэдэхгүй.



6.Сайжруулсан түлшээр гал асаахад зарцуулах модны хэмжээ, түүхий нүүрстэй харьцуулахад буурсан.


- а.Санал нийлж байна.
- б.Санал нийлэхгүй байна.
- в.Мэдэхгүй.



Сайжруулсан түлш хэрэглэснээр түлшний хэрэглээ бага зэрэг буурах ба гал асаахад зарцуулах модны хэмжээ багасахааргүй байна.


7.Сайжруулсан түлш нь хэрэглэхэд тохиромжтой.

- а.Санал нийлж байна.
- б.Санал нийлэхгүй байна.



8.Сайжруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад дутагдалтай тал нь юу байсан бэ?


- а.асахдаа удаан
- б.дутагдалтай тал байхгүй
- в.савалгаа бага, шатаж эхлэхийн өмнө үнэр гарч байна. Цог үлдэхгүй байна.



Сайжруулсан түлшийг хэрэглэх нь тохиромжтой байгаа ч түүхий нүүрстэй харьцуулахад асахдаа удаан байна.


9.Таны бодлоор сайжруулсан түлшний шатаж дуусах хугацаа түүхий нүүрстэй харьцуулахад ямар байна вэ ?

- а.Түүхий нүүрснээс удаан шатдаг
- б.Түүхий нүүрстэй адилхан.
- в.Түүхий нүүрснээс хурдан шатдаг.



10.Сайжруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад үлдэх үнсний хэмжээ ямар байсан вэ?


- а.Түүхий нүүрснээс их.
- б.Адилхан.
- в.Түүхий нүүрснээс бага.



Шатаж дуусах хугацаа нь түүхий нүүрснээс бага зэрэг удаан байгаа ба үлдэх үнсний хэмжээ түүхий нүүрстэй харьцуулахад бага байна.


11.Үнсний байдал (өнгө, хэлбэр, хэмжээ)

- а.нунтаг бор саарал
- б.хар саарал нунтаг
- в.нунтаг саарал
- г.шаргал нунтаг



12.Сайжруулсан түлш хэрэглэснээр өдөрт хэдэн удаа галлаж, хичнээн кг түлш хэрэглэж байна вэ?

- а.2удаа, 11-20кг
- б.3удаа 10-34кг
- в.4удаа 15-40кг
- г.5удаа, 20-50кг



Сайжруулсан түлш хэрэглэснээр ялгарах үнс нь нунтаг, элсэрхүү хүнд, саарал, хар саарал өнгөтэй байсан. Энэхүү түлшийг өдөрт 2-5 удаа 10-50кг түлш хэрэглэж байна.

13.Та сайжруулсан түлшийг цаашид хэрэглэх сонирхолтой байна уу?




14. Сайжруулсан түлш хэрэглээнд нэвтэрсэн тохиолдолд та ямар хэмжээгээр худалдан авах нь дээр гэж бодож байна вэ?



Санал асуулгад ороцсон иргэд энэхүү түлшийг хэрэглэхэд тохиромжтой, цаашид хэрэглэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн ба бөөнөөр авах саналтай байна.


15.1 тонн сайжруулсан түлшнийг та ямар үнээр худалдан авах саналтай байна вэ?

- а. 170000 төгрөг
- б. 150000 төгрөг
- в. 80000
- г. 100000
- д. 120000
- е. авахгүй



16. Сайжруулсан түлшийг хэрэглэхэд ямар нэгэн хүндрэл байна уу? Таны санал цаашдын ажил төлөвлөлт болон үр дүнд чухал нөлөөтэй тул өөрийн бодлыг дэлгэрэнгүй бичнэ үү

- түлэхэд хүндрэлгүй, тохиромжтой
- бэхжилт муу байна.
- нүүрснээс хурдан шатаж байна
- үнс их, цог үлдэхгүй дорхноо унтардаг.
- хаймар шатаж байгаа юм шиг үнэр гардаг. Тортог, үнс ихтэй.
- түүхий нүүрснээс дээрдэх юм байхгүй




Үнийн хувьд 1тонн сайжруулсан түлш 80,0-0-100,0 мянган төгрөг байвал хэрэглэх боломжтой гэж үзсэн.

“Баялаг Эрдэнэ цом” ХХК-ийн сайжруулсан түлш

“Баялаг Эрдэнэ цом” ХХК-ны сайжруулсан түлшийг хэрэглэсэн 22 өрхөөс 9 өрх нь энэхүү түлшийг түлэхэд 1-2 цагийн дотор шатаж дуусдаг бөгөөд гэрийг дулаацуулахгүй, ямар нэгэн цавууны хиншүү маягийн хурц үнэр гаргаж байна. Илч муу, үнс их гарна, мөн үнс нь их халуун нурамтай гарч байгаа учир гал гарч болзошгүй. Налайхын 10 кг нүүрс 12-16 цаг, энэхүү сайжруулсан түлш 40-45 кг нь 14-16 цаг дулаанаа барьж дээр нь үнс, үнэр их гарч байгаа тул цаашид түлэх боломжгүй гэсэн шалтгаанаар судалгааны 3 дахь хоногоос эхлэн уг түлшийг хэрэглэхээс татгалзсан.


Санал асуулгын дүнгээс харахад “Баялаг Эрдэнэ цом” ХХК-ны сайжруулсан түлш хэрэглэхэд тохиромжгүй, шахалт муу, шатаж эхлэхээрээ бутарч дутуу шатан үнстэй хамт хаягддаг, үнс маш их, илч муу, дулаанаа барьдаггүй, үнс нь цогтой нурам ихтэй учраас гал гарах аюултай, үнс нь хэтэрхий нунтаг хар саарал өнгөтэй, улаан нурам чигээрээ гарч байна. Хэрэглээний хувьд түүхий нүүрснээс их хэрэглэгдэх бөгөөд өвлийн хүйтэнд сууцыг халааж чадахгүй гэж үзсэн байна.



Сайжруулсан зууханд сайжруулсан түлш хэрэглэх нь тохиромжгүй яагаад гэвэл илч муу, үнс их гарч, хурдан шатдаг, дулаанаа барихгүй, шатаж дуусалгүйгээр нурам нь доошоо унадаг бөгөөд нүүрснээс илүү байж чадахгүй байна.


3. Сайжруулсан түлшээр гал асаах нь түүхий нүүрснээс хялбар.

- А. Санал нийлж байна.
- Б. Санал нийлэхгүй байна.
- В. Мэдэхгүй.



4. Сайжруулсан түлш нь түүхий нүүрстэй харьцуулахад утаа, хөө тортог бага ялгаруулдаг.


- А. Санал нийлж байна.
- Б. Санал нийлэхгүй байна.
- В. Мэдэхгүй.



Сайжруулсан түлшээр гал асаах нь түүхий нүүрснээс хялбар байж чадахгүй байна. Энэхүү түлш нь нүүрстэй харьцуулахад утаа, хөө тортог их ялгаруулж байна.


5. Сайжруулсан түлш хэрэглэснээр түлшний хэрэглээ багасна.

- А. Санал нийлж байна.
- Б. Санал нийлэхгүй байна.
- В. Мэдэхгүй.



6. Сайжруулсан түлшээр гал асаахад зарцуулах модны хэмжээ, түүхий нүүрстэй харьцуулахад буурсан.


- А. Санал нийлж байна.
- Б. Санал нийлэхгүй байна.
- В. Мэдэхгүй.



Сайжруулсан түлш хэрэглэснээр түлшний хэрэглээ багасахгүй байгаа бөгөөд гал асаахад зарцуулах модны хэмжээ түүхий нүүрстэй харьцуулахад буурахгүй байна.


7. Сайжруулсан түлш нь хэрэглэхэд тохиромжтой.

- А. Санал нийлж байна.
- Б. Санал нийлэхгүй байна.
- В. Мэдэхгүй.




8. Сайжруулсан түлшийг түүхий нүүрстэй харьцуулахад дутагдалтай тал нь юу байсан бэ?


- А. Асахдаа удаан, шаталт муу, үнс, утаа их гардаг, илч муу
- Б. Шаталт сайн, үнс, утаа бага гардаг, илч сайтай



Сайжруулсан түлш хэрэглэхэд тохиромжгүй бөгөөд нүүрстэй харьцуулахад дутагдалтай тал нь асахдаа удаан, шаталт муу, үнс, утаа их гардаг, илч муутай байна.




Сайжруулсан түлшний шатаж дуусах хугацаа түүхий нүүрстэй харьцуулахад хурдан шатдаг бөгөөд үлдэх үнсний хэмжээ түүхий нүүрснээс их байна.



Сайжруулсан түлшний үнс нунтаг хар саарал өнгөтэй, нурам чигээрээ гарч байна. Энэхүү түлшийг өдөрт 3-4 удаа 30-50 кг түлж байна.


13. Та сайжруулсан түлшийг цаашид хэрэглэх сонирхолтой байна уу?

■ А. Тийм ■ Б. Үгүй



14. Сайжруулсан түлш хэрэглээнд нэвтэрсэн тохиолдолд та ямар хэмжээгээр худалдан авах нь дээр гэж бодож байна вэ?


■ А. Бөөнөөр ■ Б. Жижиглэнгээр



Санал асуулгад оролцсон иргэд энэхүү түлшийг цаашид хэрэглэх сонирхол байхгүй байгаа бөгөөд хэрэглээнд нэвтэрсэн тохиолдолд 90% нь жижиглэнгээр худалдан авна гэсэн байна.


15. 1 тонн сайжруулсан түлшнийг та ямар үнээр худалдан авах саналтай байна вэ?

■ А. 170000 төгрөг
 ■ Б. 150000 төгрөг
 ■ В. Багануурын нүүрсний үнээс бага
 ■ Г. авахгүй



16. Сайжруулсан түлшийг хэрэглэхэд ямар нэгэн хүндрэл байна уу? Таны санал цаашдын ажил төлөвлөлт болон үр дүнд чухал нөлөөтэй тул өөрийн бодлыг дэлгэрэнгүй бичнэ үү.

■ А. Илч муу, үнс их гардаг, хурдан шатдаг, хөө тогтог их
 ■ Б. Хүйтэнд түлэхэд тохиромжгүй, үнс ихтэй
 ■ В. Дулаанаа барихгүй, хурдан шатдаг тул өдөрт олон удаа галладаг
 ■ Г. Шатаж дуусахгүйгээр бутарч унадаг, дулаанаа удаан барихгүй, түлэхэд тохиромжгүй



Нийт санал асуулгад оролцсон иргэдийн 62% нь энэхүү түлшийг худалдан авах сонирхолгүй байгаа бөгөөд худалдан авах тохиолдолд 38% нь багануурын нүүрсний үнээс бага үнээр авна гэсэн байна.

Сайжруулсан түлшийг хэрэглэхэд илч муу, үнс их гардаг, хурдан шатдаг, хөө тортог ихтэй, дутуу шатдаг, өдөрт олон удаа галладаг, хүйтэнд хэрэглэхэд тохиромжгүй, дулаанаа барьдаггүй зэрэг шалтгааныг дурьдсан.